

ХҮНДЭТ ГИШҮҮНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Спортын арбитрын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан гишүүнд “Хүндэт гишүүн”-ийн өргөмжлөл, шагнал олгох харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Хүндэт гишүүнээр журмын 2-т заасан шаардлагыг хангасан хувь хүн болон хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр дэвшүүлнэ.
- 1.3. Хүндэт гишүүддээ зориулсан үйл ажиллагаагаа хуулийн тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хүртээмжтэйгээр, ёс зүйтэй явуулна.
- 1.4. Хүндэт бүртгэлийг Ажлын албаны нарийн бичгийн дарга хариуцана.

Хоёр. Хүндэт гишүүн

- 2.1. Арбитрийн Хүндэт гишүүн нь дараах төрөлтэй байна.
 - 2.1.1. Хүндэт Ерөнхийлөгч
 - 2.1.2. Шударга ёс
 - 2.1.3. Хүндэт арбитрч
 - 2.1.4. Хүндэт гишүүн
 - 2.1.5. Хандивлагч гишүүн

Гурав. Хүндэт гишүүний тодорхойлолт

- 3.1. Хүндэт Ерөнхийлөгч
Их спортын талбарт онцгой үүрэг, гавъяа байгуулсан, шударга спортын төлөө үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын болон Монгол улсын иргэнд олгоно.
- 3.2. Шударга ёс
Их спорт, олимпизм, анагаах ухаан, хууль эрх зүйн салбарт тэгш эрх, шударга ёсыг бий болгох, сахин хамгаалах, хэрэгжүүлэхэд манлайлсан, үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын болон Монгол улсын иргэн, байгууллагад олгоно.
- 3.3. Хүндэт арбитрч
Спортын арбитрын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан гадаадын болон Монгол улсын арбитрчид олгоно.
- 3.4. Хүндэт гишүүн
Спортын арбитр, спорт, олимпизм, анагаах ухаан, хууль эрх зүйн болон бусад салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын болон Монгол улсын иргэн, байгууллагад олгоно.
- 3.5. Хандивлагч гишүүн
Спортын арбитрын хөгжил болон үйл ажиллагааг дэмжиж хандивласан гадаадын болон монгол улсын иргэн, байгууллагад олгоно.

Дөрөв. Хүндэт гишүүний эрх, үүрэг

- 4.1 Хүндэт гишүүн нь дараах нийтлэг үүрэгтэй.
 - 4.1.1. Спортын арбитраас баталсан холбогдох дүрэм, журмыг мөрдөх;
 - 4.1.2. Олон улсын тавцанд болон гадаад улсад өөрийн ёс зүй, эрхэм чанар, үнэт зүйлийг эрхмэлэн дээдлэж, үлгэрлэн харуулах;
 - 4.1.3. Өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлж бусдад үлгэр жишээ байх;
 - 4.1.4. Арбитрын нэрийн өмнөөс аливаа үйл ажиллагаанд оролцоходоо Ерөнхийлөгчид урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах;
 - 4.1.5. Дэлхийн түвшинд Хүндэт гишүүний өндөр ухамсар, нэр төр, алдар хүндийг өндөрт өргөх;
- 4.2. Хүндэт гишүүн нь дараах нийтлэг эрхтэй.
 - 4.2.1. Олон улсын болон үндэсний спортын арбитрын үйл ажиллагаанд оролцох, хариуцан гүйцэтгэж буй төрөл бүрийн ажлын хэсгүүдэд өөрийн мэргэшил, ур чадвар, ажлын туршлагын чиглэлээр сайн дурын үндсэн дээр ажиллах эрхтэй;
 - 4.2.2. Спортын арбитраас гишүүдэд зориулан бэлтгэдэг мэдээллийг хүлээн авах, сургалтад хамрагдах эрхтэй;
 - 4.2.3. Спортын арбитраас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн, зөрчигдсэн эсхүл тийм нөхцөлд байдал үүсч болзошгүй, үүсэх нь тодорхой байвал бүх талын туслалцаа, дэмжлэгийг авах эрхтэй;
 - 4.2.4. Спортын арбитрын үйл ажиллагаа, түүний тайлангийн талаарх санал, хүсэлтээ гишүүнчлэл хариуцсан ажилтанд тавих, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл авах эрхтэй.
 - 4.2.5. Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенци болон Олон улсын стандартуудын дагуух эрх;

Тав. Хүндэт гишүүний давуу тал

- 5.1. Олон улсын болон төр, засгийн байгууллагуудад салбарын болон гишүүдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, хамгаалуулах чиглэлээр Спортын арбитраас явуулж буй үйл ажиллагаанд санал дүгнэлтээ өгөх, оролцох боломжоор хангагдах;
- 5.2. Олон улсын болон дотоодын орчны талаарх мэдээ, төрөөс хэрэгжүүлэх томоохон төсөл хөтөлбөрүүдийн мэдээ, мэдээллийг хамгийн түрүүнд авах мөн түүнд оролцох;
- 5.3. Хамтын ажиллагаатай олон улсын байгууллага, холбоодын хамтын ажиллагааны саналууд, зохион байгуулж байгаа уулзалт, семинар, дугуй ширээний ярилцлага, үзэсгэлэн, арга хэмжээний мэдээллийг тогтмол авах, саналаа дотоодод болон олон улсад түгээх, хамтарсан төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах;
- 5.4. Спортын арбитраас зарим үйлчилгээг электрон хэлбэрээр авах, мэдээллийг оруулах;
- 5.5. Хүндэт гишүүдэд үзүүлдэг аливаа хөнгөлөлтүүдийг эдлэх, зохион байгуулах сургалт, хөтөлбөр, үйлчилгээнд хөнгөлөлт эдлэх, саналууд, хамтран ажиллах саналуудыг авах;

- 5.6. Спортын арбитрын дэргэдэх төв, сан, клубээр үйлчлүүлж, хуулийн болон техникийн зөвлөгөө мэдээлэл авах;
- 5.7. Олон улсын болон бүсийн уулзалт, хурал зөвлөгөөнд Спортын арбитрыг төлөөлөх оролцох;
- 5.8. Арбитрын дэргэдэх салбаруудад учирч буй хүндрэл бэрхшээлээ шийдвэрлэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой;
- 5.9. Заагдсан үйл ажиллагаанд хөнгөлөлт эдлэх;

Зургаа. Хүндэт гишүүдэд үзүүлэх дэмжлэг

- 6.1. Холбооны зүгээс гишүүдэд дараах нийтлэг дэмжлэгийг үзүүлэх ба үүгээр хязгаарлагдахгүй.
 - 6.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх,
 - 6.1.2. Салбарын хууль тогтоомж, дүрэм журам, стандартын шинэчлэлийн мэдээллийг вэб сайт, имэйл, нийтийн сүлжээгээр дамжуулан гишүүдэд хүргэж, саналыг нь нэгтгэн холбогдох байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх,
 - 6.1.3. Хүндэт гишүүний хүсэлтээр Хүндэт гишүүн болох тодорхойлолт албан бичгийг үйлдэх,
 - 6.1.4. Хүндэт гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хил хязгааргүй төлөөлөх, хамгаалах
 - 6.1.5. Спортын арбитраас хэрэгжүүлж буй стандартын шинэчлэл, судалгаа, бусад төсөлд ажилд оролцуулах,
 - 6.1.6. Хүндэт гишүүдийн уулзалт, хурал зохион байгуулах
 - 6.1.7. Хүндэт гишүүдийн хооронд ажил мэргэжлийн шинжтэй мэдээлэл, зар түгээх
 - 6.1.8. Бусад дэмжлэг

Долоо. Шагнал, урамшуулал

- 7.1. Спортын арбитрын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулж, идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Хүндэт гишүүний амжилтыг нь үнэлж Төр засгийн шагналд тодорхойлно.
- 7.2. Удирдах зөвлөлийн болон Хүндэт гишүүд, ажилчдийг шагналд тодорхойлох болзлыг Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Болзол хангасан гишүүний материалыг Шагнал урамшууллын ажлын хэсэгт ирүүлнэ.
- 7.3. Хүндэт гишүүний шагналыг Спортын арбитрын Ерөнхийлөгч гардуулна.
- 7.4. Шагнал хүртэж буй гишүүд, ажилчдыг мөнгөн шагналаар шагнаж болно.
- 7.5. Тухайн жилд идэвхи зүтгэл, санаачилгатай ажилласан Удирдах зөвлөлийн гишүүдийг Олон улсын байгууллагаас зохион байгуулж байгаа хурлуудад илтгэл тавих, ментор хийх болон бусад үйл ажиллагаанд тодорхойлж оролцуулж болно.

Найм. Хүндэт гишүүнээс хасах

- 8.1. Хүндэт гишүүн дараах зөрчлүүдийг гаргавал буцаан авах эсхүл хүчингүйд тооцно.
 - 8.1.1. Спортын арбитрын нэрийн дор хууль бус, өөрт эрх нь олгогдоогүй эрхийг ашиглаж аливаа үйлдэл хийх;
 - 8.1.2. Мэргэжлийн болон ёс зүйн ноцтой алдаа гаргаж, спортын арбитрын нэр хүндэд хохирол учруулах;
 - 8.1.3. Гэмт хэрэгт холбогдож ял шийтгэл авсан;